МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2023 оны жилийн эцсийн байдлаар тайлагнав)

**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар**

2023.12.23 Улаанбаатар хот

| Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Үндсэн хэрэгжүү-лэх байгууллага Хэрэгжүү-лэх хугацаа | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг), эх үүсвэр | Суурь түвшин | 2023 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр) Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилтийн явц, үр дүн, хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **3.2. Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| 3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. | 5."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина. | УУХҮЯ, "ЭҮ" ТӨҮГ, ТӨБЗГ<br>2020-2024 | 1,628,400.0<br>Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт (30% "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө, 70% гадаад/дотоод хөрөнгө | 0% | Үйлдвэрийн барилгын ажил үргэлжлэх, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажлыг хийнэ. 80% | 488,520.0<br>Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр ( УХОХ)-ийн санхүүжилтийн хуваарь 2.1-д заасанаар: 123,446.0 | 1,986.0 буюу УХОХ-ийн санхүүжилтийн гүйцэтгэл 1.6% | **ТӨБЗГ - ТӨУЗХ**<br>Үйлдвэрлэлийн туршилтын үйлдвэрийн төслийг БНХАУ-ын China ENFI Engineering (ENFI) компанитай хамтран хэрэгжүүлж байна. Үйлдвэрлэлийн туршилтын үйлдвэр барьж, туршилт хийх ажлыг БНХАУ-ын Шинжаан Уйгарын өөртөө засах орны Фүкүн мужид Шинжааны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна.<br>Туршилтын үйлдвэрийн бүх тоног төхөөрөмж, барилга угсралтын ажил бүрэн дууссан, туршилтад ашиглах 500 тн. шигшсэн нүүрс балттан 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр туршилтын үйлдвэрийн талбайд хүргүүлснээр |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оруулалт, зээл) | | | | | үйлдвэрлэлийн туршилтын ажлыг эхлүүлсэн. Туршилтад ашиглаж байгаа нүүрсний физик шинж чанар болон цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалсан зарим нэг хүндрэл гарч байгаа хэдий ч туршилтын ажил үргэлжилж байна.<br>Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр (ЗБХБҮ)-ийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг шинэчлэн боловсруулж байгаа бөгөөд төсөвт өртөгт шаардлагатай өөрчлөлтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-өөр батлуулсан.<br>ЗБХБҮ-ийн Байгаль орчинд нөлөөлөх нарийвчилсан үнэлгээ хийгдсэн. Техник, технологийн түвшний үнэлгээ хийх ажлын тендер зарлагдсан байна.<br>Төслийн ажлын явцын зорилтот түвшинг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 2023 онд 7.6% байхаар төлөвлөсөн бөгөөд хүрсэн түвшин 4.7% байна.<br>ЗБХБҮ байгуулах төслийн нийт төсөвт өртгийн санхүүжилтийн гүйцэтгэл нийт дүнгээр 14,440.0 сая төгрөг буюу 0.89% байна. Үүнээс Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан санхүүжилтийн 2023 оны төлөвлөгөөний гүйцэтгэл 1.6% байна.<br>Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил болох автозам, төмөр зам барих, цахилгаан хангамжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын эхлэл хийгдэж, эдгээрийн ТЭЗҮ-г боловсруулсан. Тендер зарласан. ҮТП-ийн дэд бүтцийн зураг, төслийн дагуу төсөвт өртгийн өөрчлөлтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ- |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ын 2023 оны хөрөнгө оруулалтын тодотголд тусган "Эрдэнэс Монгол" ХХК-ын ТУЗ-өөр батлуулсан. 2024 оны "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний саналыг нэгтгэн "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-өөр хамгаалах, батлуулах ажил хийгдэж байна.<br>(Дэлгэрэнгүй мэдээллийг боловсруулж, хавсаргав. Хавсралт файлаас танилцна уу)<br>**Хэрэгжилтийн хувь: 90%** |
| | 6."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна. | УУХҮЯ, "ЭҮ" ТӨҮГ, ТӨБЗГ<br>2020-2022 | 167,371.0<br>Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт 34% "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө, 66%<br>гадаад/дотоод хөрөнгө оруулалт, зээл/ | Төслийн ажлын явцаар, 0% | Нарийвчилсан зураг төсөл боловсруулах. Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулж, барьж байгуулах ажлыг эхлүүлэх. | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр ( УХОХ)-ийн санхүүжилтийн хуваарь 2.1-д заасанаар:<br>83,685.50 | 1,584.78 (нийт төсөвт өртгийн 0.95%);<br>852.4 буюу УХОХ-ийн санхүүжилтийн гүйцэтгэл 1.02%. | Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг 2023.04.04-ний өдрийн УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, АМГТГ-ын даргын "Техник эдийн засгийн үндэслэл бүртгэх тухай" 2023.04.21-ны өдрийн Т/39 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авсан.<br>Тус үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 63.8%.<br>Тус үйлдвэрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлын явц 30%. Тайланг 2024.04.26-ны өдөр хүлээн авахаар төлөвлөн гэрээ байгуулсан.<br>Тус үйлдвэрийн техник, технологийн түвшний үнэлгээ хийх ажлын тендер зарлахаар ажиллаж байна.<br>**Хэрэгжилтийн хувь – 70%** |
| **3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон | 1.Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулах хууль, эрх зүйн орчныг | БХБЯ, ТӨБЗГ<br>2020-2024 | - | - | Үйл ажиллагаа жигдэрсэн байна. | - | - | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл"-д ипотекийн хөтөлбөрийг 2023 оны эхний хагас жилд багтаан Засгийн газарт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| суурьшуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулал-таар өргөжүүлэн хэрэгжүүлнэ. | бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна. | | | | | | | шилжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд "Төрийн орон сууцны корпорац" ТӨХХК-ийг "Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац" болгон зохион байгуулж, "Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр"-ийг Засгийн газрыг төлөөлж тус байгууллагад шилжүүлэхээр Ерөнхий сайдын 2023 оны 03 дугаар 15-ны өдрийн 51 дүгээр захирамжаар Ажлын хэсэг байгуулсан.<br><br>Тус ажлын хэсгийн хурлыг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Сангийн яам, 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Барилга, хот байгуулалтын яам, 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Монголын ипотекийн корпорац ОССК дээр тус тус зохион байгуулсан. Ажлын хэсгийн хурлын үеэр ипотекийн зээлийн хөтөлбөрийг шилжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө, Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох журам, гэрээний төслийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран эцэслэн боловсруулж, танилцуулсан.<br><br>Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/2050 тоот албан бичгийг Засгийн газрын гишүүд, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх тогтоолын төсөлд санал авсан.<br><br>Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хэлэлцүүлгийн үеэр ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн бондыг Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулан, эзэмшүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Үндэсний орон сууцны корпорацыг Олон улсын донор байгууллагуудаас бие даан хөнгөлөлттэй эх үүсвэр босгох чадамжтай байдлаар чиг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үүргийг тодорхойлон бүтэц, зохион байгуулалтыг хийх, хуулийн төслийг боловсруулан 2024 оны эхний хагас жилд багтаан хэлэлцүүлэхийг үүрэг болгосон.<br>Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилтийн талаар 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Засгийн газарт, 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр иргэдийг орон сууцжуулах төслийн талаар Ерөнхий сайдад тус тус танилцуулсан.<br>Барилга хот, байгуулалтын Сайдын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 289 дүгээр тушаалаар ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, орон сууц санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх асуудлыг судалж, санал, дүгнэлт танилцуулах Ажлын хэсэг байгуулан ажиллуулсан байна. Ажлын хэсгээс гарсан санал дүгнэлтэд тогтоолын төсөлд тусган Засгийн газрын пишүүдэд 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлсэн. Уг тогтоолын төслийг 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр хэлэлцүүлэхээр бэлтгэсэн байна.<br>**Хэрэгжилтийн хувь: 70%** |
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | |
| **4.1."Цахим Монгол"- төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.** | | | | | | | | |
| 4.1.4. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх | Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia | ТӨБЗГ<br>2020-2024 | 7,360.0 | Иргэн, хуулийн этгээдэд Төрийн үйлчилгээний e-mongolia.mn системээр дамжуу- | Хоёр шатлалт 80 үйлчилгээ шинээр оруулсан байна. | 1,840.0 | - | <u>**Тайлбар:**</u><br>Энэ арга хэмжээг ТӨБЗГ-аас санал өгч тусгаагүй, алдаа үүссэн байж тул тус байгууллагаас хэрэгжилтийг хариуцан тайлагнах боломжгүй.<br>Манай байгууллагын эрхлэн хариуцах ажил биш тул үнэлгээг "Хэрэгжилтийг тооцох хугацаа |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ. | платформд холбоно. | | | лан 181 үйлчил-гээг хүргэж байна. | | | | болоогүй, үнэлэх боломжгүй" гэж авч нийт үнэлгээнд тусгасан болно.<br>**Хэрэгжилтийн хувь: Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй.** |
| | 5.Төрийн болон орон нутгийн эмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно. | ТӨБЗГ<br>2021-2024 | 1,200.0<br><br>Улсын төсөв | Програм-мын болон техник хангам-жийг сайжруу-лах шаардла-гатай. | Мэдээл-лийн санг бий болгох ажлыг шийдвэр-лэсэн байна. | 300.0 | - | **ТӨБЗГ – ТӨБАХ, МТА, ЗУХ**<br>Уг мэдээллийн системийг боловсронгуй болгоход шаардагдах нийт 1.2 тэрбум төгрөгийн төсөв Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдан зарим тендер зарлагдсан байсан нь 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэлтэй холбоотой цуцлагдсан.<br>Төсөл, арга хэмжээг "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-нд тусгахаар холбогдох журам, аргачлалын дагуу санал, үндэслэл, тайлбарыг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яаманд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А-1/96 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. Уг хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах үе шаттай ажлуудыг гүйцэтгэж, холбогдох байгууллагатай хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-нд уг асуудал тусгагдсан.<br>УИХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганаар баталсан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар улсын төсөвт уг арга хэмжээний зардалд 1,200,0 сая төгрөг тусгагдсан. Иймд холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулах, худалдан авах |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ажиллагааг зохион байгуулах зэрэг ажлуудыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж эхлээд байна. Хууль тогтоомжийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/101 дугаартай тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн систем", тоног төхөөрөмжийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулаад байна.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн болон эд хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайлангийн тухай" асуудлыг хэлэлцээд "...Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн систем"-ийг бий болгох ажлыг 2024 онд эхлүүлж, 2025 онд багтаан дуусгах, Сангийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Автотээврийн үндэсний төв зэрэг төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбох асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх нь зүйтэй" гэж 41 дүгээр тэмдэглэлд тусган шийдвэрлэсэн байна.<br><br>**Хэрэгжилтийн хувь: 100%** |
| **4.2.Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.** | | | | | | | | |
| 4.2.4.Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, | 1.Төрийн өмчийн бодлого, зохицуулал-тын асуудал хариуцсан төрийн | ТӨБЗГ<br>2021-2024 | - | Эрх зүйн орчин сул, бүтэц, орон тоо, төсөв | Төрийн болон орон нутгийн өмчийг нэгдсэн удирд- | - | - | **ТӨБЗГ – ХЭЗХ, ТӨУЗХ**<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Засгийн газраас, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно. | захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангана. | | | хангалт-гүй. | лагаар хангана. | | | тус бусад холбогдох хуулийн төслийн хамт 2022 онд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангах зохицуулалтыг тусгасан байна.<br><br>Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар байгуулсан дээрх хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэх, Эдийн засгийн Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн болон Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга нар ажиллаж байна.<br><br>Ажлын хэсэг хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэн 2023 оны 09-10 дугаар сард 7 хоногт 3-4 удаа хуралдаж, саналаа нэгтгэж байсан боловч хуулийн төслийг хууль санаачлагчаас эргүүлэн татсан. Учир нь хуулийн төсөлд зарчмын зөрүүтэй санал их, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр хуулийн төсөл шинээр өргөн барихаар болж, Ажлын хэсгийг шинээр байгуулсан.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сарын 06-ны өдөр Ажлын хэсгээс зохион байгуулсан.<br><br>Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Худалдан авах ажиллагааны газрыг шинээр байгуулж, Орон нутгийн өмчийн газрын чиг үүргээс холбогдох чиг үүргийг салгасан. Үүнтэй холбоотойгоор Орон нутгийн өмчийн газрын бүтцийн жишиг загвар, албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт хамаарах чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх хуулийн шаардлагын талаар зөвлөмж боловсруулж, ТӨБЗГ-ын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А-1/1819 дугаартай албан бичгээр 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Уг зөвлөмжид болон 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Орон нутгийн өмчийн газрын удирдлагуудтай уулзах уулзалтын үеэр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлийн төсөлд тусгагдсан холбогдох заалтын талаарх мэдээллийг тусган танилцуулсан.<br><br>**Хэрэгжилтийн хувь: 90%** |
| | 2.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад | ТӨБЗГ<br>2020-2024 | 196.0<br>Улсын төсөв | 19 хуулийн этгээд | 25 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийсэн байна. | 66.0 | 29.3 | **ТӨБЗГ – ТӨХШХ**<br><br>ТӨБЗГ-аас төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа болон эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төрийн өмчит 6 үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 18 компанид баримтын, төрийн өмчит төсөвт 10 байгууллагад системийн, нийт 34 хуулийн этгээдэд төлөвлөгөөт (төлөвлөгөөнд өөрчлөлт орсон) хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь. Тайлант |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт шалгалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна. | | | | | | | хугацаанд төлөвлөгөөт бус 4, гүйцэтгэлийн 10 хяналт шалгалтын ажлыг төрийн өмчит хуулийн этгээдэд гүйцэтгэсэн бөгөөд нийт дүнгээр 48 хяналт шалгалт хийв.<br><br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 24 хуулийн этгээдэд баримтын хяналт шалгалтыг хийж, 14 хуулийн этгээдийн дүн тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан. Нийт дүнгээр 11,677.58 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг ТӨБЗГ-ын тогтоолоор баталгаажуулсан байна. 10 хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын дүнг бэлтгэсэн, 2024 оны 1 дүгээр сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулагдахаар хүлээгдэж байна.<br><br>"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК-д хийх хяналт шалгалт (3)-ыг 2023.12.18-ны өдрөөс эхлэн хийж байна.<br><br>Засгийн газрын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх, бусад шалтгааны улмаас 2022 оны сүүлийн хагас жилд төрийн өмчит 30 хуулийн этгээдэд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын тайланг хойшлуулж, 2023 оны онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан. Эдгээр хуулийн этгээдэд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн нийт 14,842.15 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг ТӨБЗГ-ын газрын тогтоолоор баталгаажуулсан.<br><br>Хяналт шалгалтын баталгаажсан дүн, тайланг тогтоолын хамт холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авсан. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | **Хэрэгжилтийн хувь: 100%** |
| | 3.Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | ТӨБЗГ 2020-2024 | 75.0 | 7 хуулийн этгээд | 10 төсөвт байгууллагад шалгалт хийсэн байна. | 25.0 | 2.6 | **ТӨБЗГ – ТӨХШХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 онд хэрэгжүүлэх төрийн өмчийн хяналт шалгалтын төлөвлөгөө, газрын даргын баталсан удирдамжийн дагуу төрийн өмчит төсөвт 10 хуулийн этгээдэд хяналт шалгалтыг хэрэгжүүлэв. Тэдгээрээс 8 хяналт шалгалтын ажлын дүн, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, нийт дүнгээр 679,241.1 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг тогтоолоор баталгаажуулаад байна.<br><br>2 хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын дүнг бэлтгэсэн, 2024 оны 1 дүгээр сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэсэн.<br><br>Хяналт шалгалтын дүн, тайланг тогтоолын хамт холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авав.<br><br>2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу хийгдсэн Гаалийн ерөнхий газар, түүний харьяа 10 салбар нэгжийн өмчийн захиран зарцуулалтад хийсэн системийн хяналт шалгалтын дүн, тайланд тусгагдсан 113.7 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 96 дугаар тогтоолоор баталгаажуулж, холбогдох арга хэмжээг авсан байна.<br><br>**Хэрэгжилтийн хувь: 100%** |
| **4.4. Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.10. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно. | 2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулж, батална. | ТӨБЗГ 2021-2023 | - | Зарим дүрэм, журам батлах эрх хуулиар олгогдоогүй. | Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын асуудлаар 3 журмын төслийг баталж, мөрдүүлсэн байна. | - | - | **ТӨБЗГ – ХЭЗХ**<br>Холбогдох хуулийн шинэчлэл батлагдаагүй байгаа боловч төрийн өмчийн харилцааны зарим асуудлыг бусад хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд өөрчлөн шинэчлэх, боловсронгуй болгож, хуульд нийцүүлэх арга хэмжээ авч ажилласан. Тухайлбал, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ыг шинэчлэн баталсан бөгөөд төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн чиг үүргийг тодорхой болгосон. Мөн Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор "Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам", 86 дугаар тогтоолоор "Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам"-ыг тус тус баталсан. Түүнчлэн, ТӨБЗГ-ын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор "Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал"-ыг батлав. Дээрх журам, аргачлалыг мөрдүүлэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авав.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дараах тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулан үйл ажиллагаандаа мөрдөв:<br>– 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 3 дахь заалтад 2023 оны 467 дугаар тогтоолоор: |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | – 2019 оны "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолд 2023 оны 468 дугаар тогтоолоор (дуудлагын худалдааны үнэ хаялцах доод хязгаарыг нэмэгдүүлсэн, дуудлагын худалдааны тайланг ирүүлэх маягтыг 5 дугаар хавсралтаар баталсан).<br><br>**Хэрэгжилтийн хувь: 100%** |
| | 3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлнэ. | ТӨБЗГ<br>2021-2024 | - | Компа-нийн засагла-лын дундаж үнэлгээ - 53.9 хувь | Компа-нийн засаг-лалын дундаж үнэлгээг 75.0 хувьд хүргэсэн байна. | - | - | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>-Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, төрийн өмчийн төлөөлөгчийг томилох, сонгон шалгаруулах, түүнд тавих шаардлага, хэрэгжүүлэх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох зорилгын хүрээнд "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам", "Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам", "Төрийн өмчит хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам"-ыг боловсруулж, Засгийн газрын 2023 оны 84, 85, 86 дугаар тогтоолоор батлуулсан. ТӨБЗГ-ын 2023 оны 174 дүгээр тогтоолоор "Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цагийн цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал"-ыг баталж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж байна.<br><br>-Эрчим хүчний салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага менежментийг боловсронгуй болгох асуудлын хүрээнд "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн үйл |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ажиллагаа менежментийн гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэнтэй холбоотойгоор Ерөнхий сайдын 2023 оны 130 дугаар захирамжаар Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудыг өөрчлөн зохион байгуулах, ХҮТ-ийн чиг үүргийг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжийг судлах ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан.<br><br>-Засгийн газрын 2023 оны 380 дугаар тогтоолоор Төрийн байгууллагын зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг хариуцах дэд хороог байгуулан ажиллуулсан.<br><br>-Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд Олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд БНХАУ-ын Төрийн өмчийн хяналт удирдлагын хороотой хамтран "Төрийн өмчит компанийн шинэчлэл, чанартай хөгжил" сэдэвт хамтарсан форумыг Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод зохион байгуулсан. Мөн Сингапурын Засгийн газрын агентлаг болох Сингапурын хамтын ажиллагааны байгууллагатай компанийн засаглалын сайн туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар ажиллаж байна.<br><br>-"Эрдэнэс Монгол" ХХК-ийн нэгдэлд хамааруулснаас бусад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын компанийн засаглал, үр ашгийг сайжруулах зорилгоор нэгдсэн удирдлага, менежментээр хангаж ажиллах, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх үүрэг бүхий "Төрийн өмчийн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хариуцлагатай компани байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлэв.<br><br>**Хэрэгжилтийн хувь: 90%** |
| | 4.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна. | ТӨБЗГ<br>2022-2024 | - | Хуулийн этгээдэд урт болон дунд хуга-цааны бизнес /хөгж-лийн/ төлөв-лөгөө байхгүй. | Тухайн жилийн зорилтот түвшин, хөрөнгө оруулал-тын төлөв-лөгөөг баталсан байна. | - | - | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>ТӨБЗГ-аас Хувьцаа эзэмшигчийн 100 хувийн эрхийг хэрэгжүүлж буй 43 хуулийн этгээдийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулав.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/97 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 5 компани, төрийн өмчит 15 үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал, дүгнэлт боловсруулав. Нэгдсэн санал, дүгнэлтийг ТӨБЗГ-ын 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, тухайн компани, үйлдвэрийн газрын 2024 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан.<br><br>ТӨБЗГ-ын 2023 оны 341 дүгээр тогтоолоор батлагдсан хувь, хэмжээгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөв болон Ирээдүйн өв санд 2023 онд төвлөрүүлбэл зохих ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин ажилласан. 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дүнгээр улсын төсөвт төрийн өмчийн ногдол ашгийн 29.5 тэрбум төгрөг, Ирээдүй өв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | санд 376.2 тэрбум төгрөг, нийт 405.7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.<br><br>Төрийн өмчит компаниудын үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна. "Төрийн банк" ТӨХХК, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК -ийн IPO амжилттай хэрэгжиж байна. "Үндэсний давхар даатгал" ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба "Монголын цахилгаан холбоо" ХК, "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК -ийн IPO хийх бэлтгэл ажлыг хангаж байна.<br><br>Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, авто замын засвар, арчлалтын ажил эрхэлдэг төрийн өмчит 20 компанийг нийлүүлэн "Авто замын засвар, арчлалтын нэгтгэл" ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулсан.<br><br>Ерөнхий сайдын 2023 оны 130 дугаар захирамжаар Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудыг үндсэн үйл ажиллагааны чиглэлийг нь харгалзан өөрчлөн зохион байгуулах, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн чиг үүргийг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжийг судлан үзэж санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан.<br><br>Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх үүднээс харьяа төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниудын 2024 оны санхүүгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг төлөвлөх, гүйцэтгэлийг хянах, үнэлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, шийдвэр гаргалтын үйл ажиллагааг дүн шинжилгээнд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үндэслэн шуурхай болгох асуудлыг цахимжуулах ажлыг эхлүүлсэн.<br>**Хэрэгжилтийн хувь: 100%** |
| | 5.Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина. | ТӨБЗГ<br>2021-2024 | 425.0<br>Улсын төсөв | 2016 оны улсын нэгдсэн тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. | 900 хуулийн этгээдтэй байгуулсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэсэн байна. | 25.0 | 18.4<br>(өссөн дүнгээр) | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Засгийн газрын 2022 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 481 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний хүрээнд ТӨБЗГ-ын даргын 2023 оны А/23 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүн" болон "Төрийн өмчийг эзэмшүүлэх 2021 оны гэрээ"-ний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, албан даалгаврыг нийт төрийн өмчит хуулийн этгээдэд ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А-1/533 дугаар албан бичгээр хүргүүлж, хяналт тавин ажиллав.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны "Албан томилолтоор ажиллуулах тухай" А/42 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 06 дугаар сарын 05-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэлх хугацаанд орон нутагт ажиллаж, "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2022 оны биелэлтийг дүгнэх, татан буугдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эзэмшиж байсан хөрөнгийн асуудалтай холбоотой Засгийн газрын 2023 оны "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансaт шилжүүлэх тухай" 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлыг газар дээр нь зохион байгуулав. Ажлын хэсэг нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт ажиллаж, уг гэрээний 2022 оны биелэлтийг дүгнэж, өмч хөрөнгийн байдалтай танилцан ажлын хэсгийн хүлээсэн үүрэг чиглэлийн дагуу холбогдох арга хэмжээг аван ажилласан. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал"-ын 4.1-д заасны дагуу "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2022 оны үнэлгээ, дүн, дүгнэлтийг нэгтгэж, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Нийт төрийн өмчит 1026 хуулийн этгээдийн гэрээг дүгнэхээс хамрагдалт 98.5 хувь, гэрээний биелэлтийн улсын дундаж үнэлгээ 93.05 хувь байна. Гэрээний дүнгийн талаарх дүгнэлт, зөвлөмж, зөрчлийн жагсаалтыг ТӨБЗГ-ын 2023 оны 613 дугаар тогтоолоор баталгаажуулав. Уг тогтоолыг төрийн өмчит нийт хуулийн этгээдэд хүргүүлж, тогтоолыг хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авав.<br><br>**Хэрэгжилтийн хувь: 100%.** |

## ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ)-нд 2 бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтод хамаарах 5 зорилтыг хангахад чиглэсэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 онд хариуцан хэрэгжүүлэх нийт 12 арга хэмжээ тусгагдсан. Эдгээрээс 1 арга хэмжээ нь тус байгууллагын хуулиар олгосон чиг үүрэгт шууд хамааралгүй тул уг арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх боломжгүй байна. Байгууллагын үнэлгээнд нөлөөлөхгүй байх үүднээс холбогдох тайлбарыг тухайн арга хэмжээний "Хэрэгжилтийн явц, үр дүн" хэсэгт тэмдэглэн "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй" гэсэн үнэлгээний төрлөөр үнэлж, нийт дүнд тусгасан болно.

Эдгээрээс 3 арга хэмжээ нь бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн бөгөөд үүнээс "Эрдэнэт үйлдвэр"-ийн Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хүрээнд хэрэгжүүлэх 2 арга хэмжээний тухайд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяанд ажиллахгүй болсон. Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн харьяанд нэгдлийн хэмжээнд ажиллуулахаар шийдвэрлэсэн.

**<u>Үнэлгээний дүнгийн товч танилцуулга (2023 оны жилийн эцсийн байдлаар):</u>**

ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан арга хэмжээ (заалт)-ний тоо – **12**; Үүнээс:

- 100 %-ийн хэрэгжилттэй – 6 арга хэмжээ;
- 90 %-ийн хэрэгжилттэй – 3 арга хэмжээ;
- 70 %-ийн хэрэгжилттэй – 2 арга хэмжээ;
- 50 %-ийн хэрэгжилттэй – 0 арга хэмжээ;
- 30 %-ийн хэрэгжилттэй – 0 арга хэмжээ;
- 0 % – 0 арга хэмжээ;
- Хугацаа болоогүй, хүлээгдэж байгаа /Үнэлэх боломжгүй/ – 1 арга хэмжээ.

Хэрэгжилтийн дундаж үнэлгээ – **91.82% буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" байна.**

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Н.ГАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ

Нэмэлт мэдээлэл ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас өгсөн мэдээлэл)

### 3.2.7.5. ЗЭСИЙН БАЯЖМАЛЫН ҮЙЛДВЭР ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас өгсөн мэдээллийг хавсаргав)

"Эрдэнэт үйлдвэр"-т үйлдвэрлэл, технологийн парк (ҮТП) байгуулах ажлын хүрээнд **Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр (ЗБХБҮ) байгуулах төсөл (2021-2025)**

**Төслийн зорилго:** жилд 560 мян.тн зэсийн баяжмал боловсруулж, 124.1 мян.тн/жил катодын зэс, 182 мян.тн/жил хүхэр үйлдвэрлэх.

**Шалгуур үзүүлэлт:** Төслийн ажлын явцаар,

2023 оны шалгуур үзүүлэлт:
- суурь түвшин 1 %
- зорилтот түвшин 7.6 %
- хүрсэн түвшин 4.7 %

**Төсөвт өртөг, гүйцэтгэл:**

Нийт төсөвт өртөг 1,628,400.0 сая төгрөг, ТЭЗҮ-ийн тооцоонд: 30% "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, 70%-ийг Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт, зээлээр.

- 2020 оны санхүүжилтийн гүйцэтгэл 3,340.3 сая төгрөг
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн хуваарь 2023 онд 123,446.0 сая төгрөг
- 2023 оны санхүүжилтийн гүйцэтгэл (УХОХөтөлбөрт тусгагдсан төсвийн төлөвлөлтийн хуваарь)-ийн гүйцэтгэл 1,986.0 сая төгрөг (1.6%)
- Нийт төсөвт өртгийн санхүүжилтийн гүйцэтгэл 14,440.30 сая төгрөг (0.89%).

**2023 онд гүйцэтгэсэн ажил:**

1. Үйлдвэрлэлийн туршилтын ажилд шаардлагатай нүүрсийг бэлтгэж, БНХАУ-д хүргүүлсэн.

2. ҮТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн. Үүнд:

    2.1. Автозам барих
    2.2. Төмөр зам барих
    2.3. Цахилгаан хангамжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах
    2.4. Ус хангамж, ариутгал татуургын систем барьж байгуулах

3. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдсэн.

4. Техник, технологийн түвшний үнэлгээ хийх ажлын тендер зарлагдсан.

**Нэмэлт тайбар: /Ажлын явц, санхүүжилтийн гүйцэтгэлд үүссэн зөрүү зэрэг/**

- ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-нд хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Зэсийн үнэ 8340 $/тн.-ны түвшинд 762 сая ам.доллар буюу 2,171,700 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан.

- ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх **үйлдвэрлэлийн туршилтыг** БНХАУ-ын Шинжаан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Туршилтын үйлдвэрийн бүх тоног төхөөрөмж, барилга угсралтын ажил 100% дууссан ба туршилтад ашиглах 500 тн шигшсэн нүүрс бэлтгэн 2023.09.29-ний өдөр туршилтын үйлдвэрийн талбайд хүргүүлснээр үйлдвэрлэлийн туршилтын ажлыг эхлүүлсэн. Туршилтанд ашиглаж байгаа нүүрсний физик шинж чанар болон цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалсан зарим нэг хүндрэл гарч байгаа хэдий ч туршилтын ажил үргэлжилж байна.

- "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын [illegible]-ны өдрийн [illegible] тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо 2022.12.06-ны өдөр хуралдаж, ЗБХБҮ-ийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын тендерийг гэрээ шууд байгуулах журмаар зохион байгуулах зөвлөмж захиалагчид хүргүүлсэн байна. "ЭҮ" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд уг ажлын төсөвт өртөгт шаардлагатай өөрчлөлтийг оруулан тусгаж, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-өөр батлуулсан. Үйлдвэрлэлийн туршилтын ажил нь анхны төсөөллийг илүү тодруулж харуулахад чиглэгдсэн бөгөөд ЗБХБҮ-ийн төслийг хөгжүүлэхэд ямар нэг саад бэрхшээл болохгүй гэдгийг ENFI компаниас албан ёсоор мэдэгдэж, ЗБХБҮ-ийг барьж байгуулах төслийн ажилд хөрөнгө оруулалт хийх, цаашид хамтарч ажиллах сонирхолтой байгаа илэрхийлсэн.

- ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-д УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-өөс өгсөн зөвлөмжийн дагуу "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах" ажлыг гүйцэтгэж байна. Уг зөвлөх үйлчилгээний тендерт "Эс Ай Си Эй" ХХК шалгарч, гэрээ байгуулан (гэрээний дүн 346 сая төгрөг) ажиллаж байна. 60%-ийн санхүүжилт (207.6 сая төгрөг) хийгдсэн. Ажлын явц 80%.

- Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг "ЭҮ" ТӨҮГ-ын Судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг ШУТИС-ын УУХ-ГУУС-тай гэрээ байгуулан ажиллаж, тайланг (гэрээний дүн 148.8 сая төгрөг, 2022 онд) хүлээн авсан.

- "Фосфорын ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг төлөвлөсөн боловч фосфорын ордын ашиглалтын лиценз хувийн компанийн эзэмшилд байдаг шалтгаанаар гүйцэтгэх боломжгүй болсон.

- ЗБХБҮ-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-г "Хатан далай" ХХК гүйцэтгэсэн (гэрээний дүн 118.8 сая төгрөг). БОАЖЯ-ны мэргэжлийн комиссын 2023.08.30-ны хуралдаанаар тайланг хүлээн авахаар шийдвэрлэсэн. Ажлын явц 100%.

- ЗБХБҮ-ийн техник, технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж батлуулсан (төсөв 150 сая төгрөг). Тендер хүчингүй болсон.

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн ТЭЗҮ, БОННҮ, Ерөнхий төлөвлөгөө батлагдсан.

ҮТП-ийн бүтээн байгуулалтын эхний ажил болох дэд бүтцийн ус хангамж, ариутгах татуургын систем, авто зам, төмөр замын зураг төсөл, цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг боловсруулсан. Зураг төсөл, ТЭЗҮ-ийн дагуу ҮТП-ийн дэд бүтцийг барьж байгуулах тендер зарлагдсан. ҮТП-ийн дэд бүтцийн зураг, төслийн дагуу төсөвт өртгийн өөрчлөлтийг "ЭҮ" ТӨҮГ-ын 2023 оны хөрөнгө оруулалтын тодотголд тусган "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-өөр батлуулсан. 2024 оны "ЭҮ" ТӨҮГ-ын ХО-ын төлөвлөгөөний саналыг нэгтгэн "Эрдэнэс Монгол" ХХК-ын ТУЗ-аар хамгаалах, батлуулах ажил хийгдэж байна.

- Үйлдвэрлэл, технологийн паркийн газрын эзэмших, ашиглах газрын хил заагийн эргэлтийн цэгийг тэмдэгжүүлж, солбицол тодорхойлох, шалгах ажил хийгдсэн.

- Үйлдвэрлэл технологийн паркийн газрын 1:500 масштабтай байрзүйн дэвсгэр зургийг боловсруулсан.

- ҮТП-ын газрыг тойруулан хашаа барих ажлын тендерт шалгарсан "Орчлонтулга" ХХК-тай 2022.12.05-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. 16 км хашаа баригдахаас одоогоор 14 км баригдсан. Газрын хил хязгаар, дэд бүтцийн зураг төслийн давхцал үүссэн тул асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Ажлын явц 90%.

**ҮТП-ийн дэд бүтцийн ажлын явц:**

- Авто зам барьж байгуулах ажлын тендерийг 2022.06.30-наас 2023.01.25-ны хооронд 4-н удаа тендер зарлаж, автозамын гэрэлтүүлэг барьж байгуулах 2-р багцад "Оркон тех" ХХК, автозам барьж байгуулах 1-р багцад "Шилдэг зам" ХХК шалгарч, гэрээ байгуулсан ба

2024.11.01-нд гэрээний хугацаа дуусна. Автозамын захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээний тендер "Мөнхөд ашдын зам" ХХК шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын явц 36%.

- Төмөр зам барьж байгуулах ажлын тендерийг 2 удаа зарлаж, "Туулын гүүр далай" ХХК шалгарч, гэрээ байгуулсан ба 2023.12.31-нд гэрээний хугацаа дуусна. Төмөр замын зохиогчийн хяналтын гэрээг "Максимал" ХХК-тай байгуулсан. Төмөр замын захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээний тендерт "Рэйлвэй консалтинг Сервис" ХХК шалгарч, гэрээ байгуулагдсан. Ажлын явц 68%. Ул хөрсний төлөвлөгдөөгүй нэмэлт ажил болон цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан гэрээний хугацаанд ажил гүйцэтгэх боломжгүй болж, гэрээ сунгах ажил явагдаж байна.

- Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын тендерийг 2022 оны 05 дугаар сараас эхлэн зарласан боловч СЯ, ШӨХТГ-т гомдол гарах, тендер хүчингүй болох зэрэг шалтгаанаар өнөөдрийг хүртэл гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж чадаагүй байна. 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр шүүх хурал болж, тендерт оролцогчийн гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэж, тендерийг дахин зарлах эрх зүйн байдал үүссэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг АУХААХ-с 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдөр дахин зарласан боловч ШӨХТГ-т гомдол гарсан тул гомдлыг хянан шалгах үйл ажиллагаа үргэлжилж байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр хүлээгдэж хугацаа алдсан. Гэрээ байгуулах ажил хийгдэж байна.

- ҮТП-ийн цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг 2022 оны 05 дугаар сард ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. ТЭЗҮ, Диспетчерийн үндэсний төвийн горимын тооцоо зэргийг үндэслэн ЭХЯ-наас ҮТП-ийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг авсан. 2022.11.01-ны өдөр цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг боловсруулан ирүүлсэн. Дээрх ажлыг богино хугацаанд хийх зорилгоор "ЭҮ" ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэнгээр "ҮТП-ийн цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл хийлгэх тухай" "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий инженерийн 2023.02.09-ны өдрийн шийдвэр гарсан. Төсөв батлагдаж, ажил эхэлсэн. Нарийвчилсан зураг төслийг 2023.12.31-ны дотор хийж дуусгахыг ЗТХ-д даалгасан. Төсвийн дагуу программ хангамжийг худалдан авсан. 2 зөвлөх инженертэй гэрээ байгуулсан, ажил үргэлжилж байна. Ажлын явц 35%. Зураг төслийг боловсруулах явцад төвөгшилтэй ажлууд гарч (МУ-ын 110 кВ-ын шугам кабелийн стандарт батлагдаагүй) удааширсан бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн өндөр ур чадвар, шинэлэг инновац бүхий шийдэл гаргаж нэвтрүүлэх шаардлага үүссэн тул ЦДҮС ТӨХК, ТӨБЗГ, ЭХЯ-нд хандсан. "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ-тай хамтран ажиллахаар "ЭҮ"-ийн техникийн зөвлөлийн 2023.11.24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулан, ажиллаж байна.

**Төслийн зорилгын биелэлтэд учирч буй саад бэрхшээл, эрсдэл:**

ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтын ажил Ковид цар тахал өвчнөөс шалтгаалан БНХАУ-т хатуу хөл хорио тогтоосоноос 2022 онд ажил бүрэн зогссон, 2023 онд үйлдвэр барьж байгуулах ажил үргэлжилсэн.

Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэр (ЗБХБҮ) байгуулах ажлын хүрээнд:

- ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтын ажил үргэлжилж байна.

- ЗБХБҮ-ийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг шинэчлэн боловсруулж байна.

- ЗБХБҮ-ийн Техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын тендер нээж хүчингүй болсон. Дахин зарласан.

- Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг үйлдвэрийн судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна.

/"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын мэдээлэл/

Нэмэлт мэдээлэл ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас өгсөн мэдээлэл)

### 3.2.7.6.ИСЭЛДСЭН ХҮДРИЙГ НУРУУЛДАН УУСГАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛНА

"Эрдэнэт үйлдвэр"-т үйлдвэрлэл, технологийн парк (ҮТП) байгуулах ажлын хүрээнд **Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл (2021-2022)**

**Төслийн зорилго:** исэлдсэн хүдрээс 10000 тн/жил катодын зэс үйлдвэрлэх.

**Шалгуур үзүүлэлт:** Төслийн ажлын явцаар,

2023 оны шалгуур үзүүлэлт /УХОХ-т/:

- суурь түвшин 0 %
- зорилтот түвшин 50%, /Нарийвчилсан зураг төсөл боловсруулах. Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулж барьж байгуулах ажлыг эхлүүлэх.
- хүрсэн түвшин 9 %

**Төсөвт өртөг, гүйцэтгэл:**

Нийт төсөвт өртөг 167,371.0 сая төгрөг, ТЭЗҮ-ийн тооцоонд: "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ.

- 2020 оны санхүүжилтийн гүйцэтгэл - 0 төгрөг
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн хуваарь 2023 онд 83,685.50 сая төгрөг
- 2023 оны санхүүжилтийн гүйцэтгэл (УХОХөтөлбөрт тусгагдсан төсвийн төлөвлөлтийн хуваарь)-ийн гүйцэтгэл 852.4 сая төгрөг (1.02%)
- Нийт төсөвт өртгийн санхүүжилтийн гүйцэтгэл 1,584.78 сая төгрөг (0.95%).

**2023 онд гүйцэтгэсэн ажил:**

1. Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг 2023.04.04-ны өдрийн УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, АМГТГ-ын даргын "Техник эдийн засгийн үндэслэл бүртгэх тухай" 2023.04.21-ны өдрийн Т/39 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авсан.
2. Тус үйлдвэрийн нраийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 63.8%
3. Тус үйлдвэрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлын явц 30%. Тайланг 2024.04.26-ны хүлээн авахаар төлөвлөн гэрээ байгуулсан.
4. Тус үйлдвэрийн техник, технологийн түвшний үнэлгээ хийх ажлын тендер зарлахаар ажиллаж байна.

**Нэмэлт тайбар: /Ажлын явц, санхүүжилтийн гүйцэтгэлд үүссэн зөрүү зэрэг/**

"SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээний гэрээг "ЭҮ" ТӨҮГ болон "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-хооронд 2021.09.17-ны өдөр байгуулсан.

Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2023.04.04-ны өдөр хэлэлцүүлж, АМГТГ-ын даргын "Техник эдийн засгийн үндэслэл бүртгэх тухай" 2023.04.21-ны өдрийн Т/39 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авсан.

Батлагдсан ТЭЗҮ-ээр: зэсийн үнэ 8500$/тн-оор тооцож, нийт хөрөнгө оруулалт 109.8сая.$ буюу 362.4 тэрбум төгрөг, үүнийн анхны хөрөнгө оруулалт 197.6 тэрбум төгрөг, ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт 164.8 тэрбум төгрөг болсон.

"SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-д гэрээний дагуу 2021.11.24-ний өдөр 30% буюу 732.38 сая төгрөг, ажлын хэсгийн хурлын шийдвэр болон тайлангийн явцын гүйцэтгэлээр 2023.05.31-ний өдөр 33.8% буюу 852.4 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд нийт 1,584.78 сая төгрөгийн санүүжилт хийгдсэн.

2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд: байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх ажилд 142.5 сая төгрөг, техник технологийн түвшний үнэлгээ

хийх ажилд 100 сая төгрөг, ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын урьдчилгаа төлбөрийг тус тус төлөвлөсөн.

**Төслийн зорилгын биелэлтэд учирч буй саад бэрхшээл, эрсдэл:**

<u>Хугацаа алдсан шалтгаан:</u> тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2022.06.24-нд хэлэлцүүлсэн боловч "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөл 2022.10.13-нд хуралдаж "Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "ЭҮ" ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Техникийн зөвлөл 2022.11.02; 04-ний өдрүүдэд хуралдаж "ЭҮ-ийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжийн дагуу ТЭЗҮ-ийг засварлан боловсруулах, үүнд шаардлагатай хугацааг харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгах, ТЭЗҮ-ийг засварласны дараа техникийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу ажлын хэсэг 2022.11.17-ны өдөр хуралдаж гэрээний хугацааг 2023.03.31-ний өдөр хүртэл сунгах саналыг ХОХААБГ-т, Техникийн зөвлөлийн шийдвэрийг гүйцэтгэгч компанид тус тус албан бичгээр хүргүүлсэн. Гүйцэтгэгч компаниас 2022.11.22-ны өдрийн 038/22 дугаар албан бичгээр ЭҮ-ийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжид өгсөн тайлбарыг ирүүлсэн. Ерөнхий захирлын 2022.12.09-ний өдрийн А/818 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хуульч, эдийн засагч нэмж, мөн ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн даргыг өөрчлөн томилсон. Гүйцэтгэгч компанитай цахим хурал 2022.12.14-нд зохион байгуулж, ТЭЗҮ-ийг шинэчлэн засварлахаар тохиролцсон. 2023.04.24-ний өдөр "ЭҮ" ТӨҮГ-ын 2022.12.09-ний өдрийн А/818 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хуралдаж ажлын гүйцэтгэлийг 63.8% (2021 онд 30% санхүүжилт олгосон) гэж үнэлж 33.8%-ийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн ба санхүүжилтийг 2023.05.31-ний өдөр гүйцэтгэгч компанид олгосон. "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны хуралдааны шийдвэрийн дагуу Техникийн зөвлөл 2023.05.12-ны өдөр хуралдаж "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-аар SX/EW үйлдвэрийн Нарийвчилсан зураг төслийг үргэлжлүүлэн хийлгэхээр шийдвэрлэсэн. 2023.06.05-ны өдөр гүйцэтгэгч компаниас "Архитектур төлөвлөлтийн даалгавар авах тухай" албан бичиг ирүүлсэн ба ҮТП-ийн газрын гэрчилгээг УУХҮЯ эзэмшдэг тул 2023.06.08-ны өдөр УУХҮЯ-ны ХҮБГ-т "Цахим системээр хүсэлт илгээх тухай"албан бичгийг хүргүүлсэн. Нарийвчилсан зураг төсөл боловсруулахад шаардлагатай усан хангамжийн техникийн нөхцөлийг 2023.06.13-ны өдөр гүйцэтгэгчид хүргүүлсэн ба Цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг ЭХЯ-аас авах ажлыг "ЭҮ" ТӨҮГ-ын Эрчим хүчний хэлтэс гүйцэтгэж байна. 2023.06.02-ны өдрийн А/353 тоот тушаалаар Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан ба 2023.06.20-ны өдөр "SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах" ажлын гэрээний хугацаа дууссан. 2023.06.20-ны өдөр "ЭҮ"ТӨҮГ-ын Ерөнхий захирлаас гүйцэтгэгч компанид "Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлэх"-ийг шаардсан албан бичгийг хүргүүлэхэд "Архитектурын даалгавар авах хүсэлтийг удаа дараа хүргүүлсэн буюу ЭҮ-ээс хамааралтай ажлаас болж хугацаа сунаж байна" гэсэн утгатай хариу ирүүлсэн.

Ажлын хэсэг 2023.10.05; 30-ны өдрүүдэд хуралдаж "ЭҮ" ТӨҮГ нь зураг төслийг боловсруулахад шаардлагатай Архитектор төлөвлөлтийн даалгавар, цахилгааны техникийн нөхцөлийг гэрээний хугацаанд гүйцэтгэгч "Майнинг шорт лонг терм" ХХК-д гаргаж өгч амжаагүй учир гэрээний хугацааг сунгах санал гаргаж дээд шатны удирдлагад хүргүүлсэн.

"ЭҮ" ТӨҮГ нь аливаа гэрээний хугацааг сунгахгүй буюу ажлыг цаг хугацаанд нь гүйцэтгүүлэх бодлого баримталж байна. Иймд гэрээний хугацааг сунгах эсэх нь одоогоор тодорхойгүй байна.

Гүйцэтгэгч компанид "Архитектор төлөвлөлтийн даалгавар"-ыг 2023.12.08-ны өдөр хүргүүлсэн. "Цахилгааны техникийн нөхцөл"-ийг 2023.12.15-ны дотор хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Исэлдсэн хүдрийг SX/EW технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлын тайланг 2024.04.26-ны хүлээн авахаар төлөвлөн гэрээ байгуулсан.

/"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын мэдээлэл/